

**ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Монгол Улсын харьяат болох нөхцөлийг амьжиргааны зохих чадвар, эх үүсвэртэй байх, Монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн ба иргэний харьяатын асуудлаар өргөдөл гаргасан өдрөөс өмнө Монгол Улсын нутаг дэвсгэр дээр таваас доошгүй жил байнга оршин суусан байхаар заасан. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болно.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “Улсын Их Хурал биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлого”-ын “2021-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний 3.5.13-т Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Практик шаардлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын зүгээс спортоор дамжуулан энх тайван, эв нэгдэл, эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийг ухуулан таниулахад ихэд ач холбогдол өгдөг. Өөрийн улсын нэрийг гаргах, түүгээр дамжуулан амжилт гаргах, өсөн дэвжих боломжтой улс орон хэмээн бусдад хоногшуулахад спортын гүйцэтгэх үүрэг улам нэмэгдсээр байна.

Улс орнууд спортоор дамжуулан, үндэстний амин чанар, бахархлаа улам бэхжүүлэх, шинэ залуу үеийнхэнд үндэстний үнэт зүйлсээ таниулах, бэхжүүлэх, хүсэл мөрөөдөлтэй болгох зорилготой ажиллахын зэрэгцээ спорт түшиглэсэн аялал жуулчлал, үзвэр, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Олимпын үзэл санааг дэлгэрүүлэх, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор, спортын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч, амжилт гаргах магадлалтай гадаадын иргэдэд харьяалал олгон өөрийн улсын нэр дээр оролцуулдаг зохицуулалт гадаадын улсуудад үйлчилж байна. Тухайлбал,

Бүгд Найрамдах Хятад Ард Улс сагсан бөмбөг, хөл бөмбөг, уран гулгалт, цана, хоккей, атлетик, уран гимнастик зэрэг спортын төрөлд амжилт гаргасан тамирчдыг харьяат болгож, үндэсний багийн бүрэлдэхүүнд багтаадаг. Харьяатын хувьд дотоодын хууль тогтоомжоор давхар иргэншилтэй байхыг хориглодог.

Япон Улс олимпын болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн гадаадын тамирчдыг тусгай журмын¹ дагуу харьяат болгох бодлого хэрэгжүүлдэг. Энэ нь Япон Улсын спортын нэр хүндийг өсгөхөд ихээхэн нөлөө үзүүлсэн. Сумо, бэйсбол, хөл бөмбөг, софтбол, одон бөмбөг, сагсан бөмбөг, волейбол, регби зэрэг спортын амжилттай тамирчдыг харьяат болгодог ажээ.

Бүгд Найрамдах Солонгос Улс олимпын наадмаар амжилт гаргасан гадаадын тамирчдыг тусгай журмаар Солонгосын иргэншилд хамруулж, үндэсний шигшээ багийн чадамжийг нэмэгдүүлсэн туршлагатай.

Бүгд Найрамдах Казахстан Улс бокс, хүндийн өргөлт, жүдо зэрэг спортоор гадаадын шилдэг тамирчдыг иргэн болгож, олон улсын тавцанд амжилт гаргах бодлого хэрэгжүүлсэн нь олимп, дэлхийн тэмцээнд амжилтаар баталсан.

¹ Япон Улсын иргэнтэй гэр бүлийн харилцаатай амьдарч байгаа тохиоолдолд хялбаршуулсан журмаар харьяат болох боломжтой төдийгүй “онцгойлон харьяат болгох” гэсэн журмын өөр зохицуулалт байдаг.

2024 онд Монгол Улсад биеийн тамирын салбарт үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тус салбарынхан тэмдэглэн өнгөрүүлэхийн зэрэгцээ салбарын мэргэжилтнүүд ийнхүү түүхэн хугацаанд гаргасан оломж амжилт, алдаа сургамжид анхааран хандуулж дүгнэсэн арга хэмжээг олон удаа зохион байгуулж хэлэлцүүлсэн байдаг. Ялангуяа нийтийн биеийн тамир, үндэсний спортоос гадна олимпын спортын төрлийг дэмжин хөгжүүлэх, спорт дахь хүний нөөцийг бэлтгэх, энэ талаар дэвшилтэд алхам хийх шаардлага байсаар байна.

Биеийн тамир, спортын улсын хорооноос гаргасан албан ёсны статистикаар Монгол Улсад 2023 онд нийт 140932 тамирчин бүртгэгдсэн байна. Нийт тамирчдын дийлэнх хувийг буюу 68214 (48.4%) нь спорт тоглоом, 23798 (16.9%) нь үндэсний спорт, 15824 (11.2%) нь халз тулаан, хүчний спорт, 17406 (12.4%) оюуны спорт, 12423 (8.8%) хэмжигдэхүүнтэй спорт үлдсэн 3267 (2.3%) пара болон цэрэгжилтийн спортын тамирчид байна.² Харин дээрх мэдээлэлд олимпын хөтөлбөрт багтдаг спортын төрлөөр хичээллэдэг тамирчдын нэгдсэн тоо тодорхой байхгүй байна.

Манай улс олимпын түүхэн хугацаанд медаль авсан спортын төрөл нь жудо, чөлөөт бөх, бокс, буудлагын спорт байдаг. Цаашид олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын бусад төрлийг хөгжүүлэх, багийн спортыг хөгжүүлэх, эдгээр төрөлд хүний нөөц бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхэд тамирчид, спортын холбоод, клубүүд, зүтгэлтнүүдийн оролцооноос гадна төрөөс эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага байсаар байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад багийн спорт харьцангуй эрчимтэй хөгжиж, олон улсын тэмцээн уралдаанд гадаадын легионер тамирчинг урьж тоглолт хийх зэрэг нь нийтлэг болж байна.

Монгол Улс гадаад улсын тамирчдыг улсынхаа нэрийн өмнөөс спортын тэмцээнд оруулах шаардлага байгаатай зэрэгцэн Монголын тамирчид ч бусад улсын нэрийн өмнөөс олон улсын тэмцээнд оролцож байна. Тухайлбал жудо бөхийн тамирчин Г.Отгонцэцэг Бүгд Найрамдах Казахстан Улс, буудлагын спортын тамирчин Д.Мөнхбаяр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн болж тус улсын нэрийн өмнөөс олимп, дэлхийн тэмцээнд оролцон амжилт гаргасныг онцолж болох юм.

Манай улсын хувьд Ираны жудо бөхийн тамирчин Моллаей Саеид нь Монгол Улсын иргэн болж олимпын мөнгөн медаль хүртэн амжилттай оролцсон, Монгол Улсад зохион байгуулагдсан шайбтай хоккейн IV дивизионы дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монголын баг тамирчдыг амжилттай дасгалжуулсан Оросын

² “Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2023 БТСГазар

Холбооны Улсын иргэн Бату нарыг дурдаж болно. Мөн хөлбөмбөгийн холбоо, сагсан бөмбөгийн холбоо болон бусад спортын мэргэжлийн холбоодоос өндөр түвшний мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчдыг Монгол Улсын харьяат болгож, Монголын нэрийн өмнөөс олон улсын тэмцээнд оролцуулах хүсэлт удаа дараа ирүүлж байгаа зэрэг бодит шаардлагууд гарсаар байна.

Спортын салбарын шилдэг төлөөлөгчдийг иргэншил олгох байдлаар татах нь тэдний мэдлэг, туршлага, ур чадвараар Монгол Улсын залуу үеийг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын хэмжээнд спортын амжилтаараа нэр хүндтэй болохын зэрэгцээ гадаад улс орнуудтай харилцаагаа сайжруулах зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, Монгол Улс дэлхий дахинд илүү танигдах, үнэлэгдэх боломжийг нэмэгдүүлэхээр байна.

Түүнчлэн биеийн тамир, спортын талаар тусгагдсан Монгол Улс дахь хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд нь спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, спортын олон төрлийг хөгжүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгод нэгдэж байна гэж үзэхээр байна.

Төрөөс спортыг мэргэжлийн болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, зарим спортын төрөл сонгон авч хөгжлийн загвар гаргах, шинэ тутам хөгжиж байгаа спортын төрлүүдийг бодлогын түвшинд дэмжих, ирээдүйд олимпод орох боломжтой спортын төрлийг одоогоос дэмжих зэрэг саналуудыг спортын зүтгэлтнүүд, хөрөнгө оруулагчид ч гаргасаар байна.

Аливаа төрлийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дэмжлэгийн үндсэн арга хэлбэр бол эрх зүйн орчинг бүрдүүлэх явдал билээ. Манай улсын хувьд Харьяатын тухай хуульд Монгол Улсын харьяат болох онцгой тохиолдлыг заасан байдаг бөгөөд Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийхээ хүрээнд харьяат болгох эсэхийг шийдвэрлэж болох нээлттэй зохицуулалт нэгэнт үйлчилж байна.

Иймд спортын хөгжлийг дэмжих, хүний нөөцийг бэлтгэх, ялангуяа олимпын спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болох агуулга бүхий нэмэлт оруулахаар боловсруулах нь зүйтэй байна.

Иймд дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болох хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтад “олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэн”-ийг хамааруулах агуулгатай нэг зүйл, нэг заалт бүхий зохицуулалттай хуулийн төсөл боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагаварын талаар:

Хуулийн дээрх зохицуулалтад олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргах боломжтой гадаадын иргэнийг хамааруулах зохицуулалтыг нэмж тусгаснаар дэлхийн хэмжээний өндөр амжилт гаргасан гадаадын тамирчдыг Монгол Улсын иргэн болгон улсын нэрийн өмнөөс оролцуулж олон улсын тэмцээнүүдэд амжилт гаргах боломж нэмэгдэж, дотоодын тамирчдад мэдлэг, ур чадвар, арга барил дамжуулах нөхцөл бүрдэх юм. Мөн олон улсын өндөр зэрэглэлийн тамирчид Монгол Улсын нэрийн өмнөөс тэмцээн уралдаанд оролцсоноор залуучуудын спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлж, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих чухал нөлөөтэй.

Спортын салбарт онцгой амжилт гаргах боломжтой гадаадын иргэдийг харьяат болгосноор Монгол Улсын иргэдийн спортод хандах хандлага сайжирч, залуучуудын дунд идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлэх, үндэсний бахархал, эв нэгдлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Спортын амжилт, нэр хүнд, эдийн засгийн өсөлт нь харилцан уялдаа бүхий хүчин зүйл гэдгийг анхаарч, спортын нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөг хүлээн зөвшөөрч Монгол Улсын иргэний харьяаллын бодлогыг уян хатан, хөгжлийн хөшүүрэг болохуйц зохицуулалт бүхий болгох боломжтой үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан

боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

---o0o---